



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

Г Улирлын томуугийн эсрэг
вакцинаар дархлаажуулах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/359 дүгээр тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг дүүргийн хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Улирлын томуугийн дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Дүүргийн эрсдэлт бүлгийн хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүд, бүх хэлбэрийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 6 сараас 5 хүртэлх насны хүүхдүүд эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг хуваарийн дагуу улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах, мөн “Дархлаажуулалтын 10 хоног”-оор цэцэрлэгийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хамтатган чанарын стандартын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
4. Заавал хийх товтолт дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдүүдийг нөхөн дархлаажуулах, вакцины хүйтэн хэлхээ, аюулгүй дархлаажуулалтын холбогдох тушаал, зааврыг нягт баримтлах, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтыг эрчимжүүлэн, бүртгэдсэн тохиолдлыг цаг хугацаанд нь мэдээлэх, тандан судлах, хариу арга хэмжээг авч ажиллахыг Дархлаажуулалтын сувилагч (О.Удвал)-д үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтын 10 хоногийн хугацаанд ажилласан эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдын илүү цагийн хөлсийг холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн олгох, эсвэл биеэр нөхөн амруулах ажлыг зохион байгуулахыг Хүний нөөцийн ажилтан (Г.Гантуяа)-д даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Гантуяа)-д үүрэг болгосугай.



Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн
А/33 тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|----------------------|------------|---------------|
| Ажлын хэсгийн ахлагч | Их эмч | Ч.Баасанноров |
| Гишүүн | Их эмч | О.Номиндалай |
| | Их эмч | О.Лхагвацэцэг |
| | Сувилагч | М.Оюунтүлхүүр |
| Нарийн бичгийн дарга | Статистикч | О.Удвал |